



**ӨЛЗИЙТ СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

1

**Аудитын код: АРА-
2017/9/СТА-ТШЗ**

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Менежмент захидал

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70333141
Цахим хаяг:

Аудитын менежер:
Утас: 70332860
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Архангай
аймгийн Аудитын газар
Байршил: Эрдэнэбулган
сум
Цахим хуудас:
www.audit.mn

2017.03.23

1 Агуулга

1		0
2	Аудитын гэрчилгээ	2
3	Аудитын тайлан	4
3.1	Оршил	4
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
3.4	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
3.5	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
3.6	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
3.7	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
3.8	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
3.8.1	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
3.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
3.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
3.11	Шилэн дансны мэдээлэл	9
3.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
3.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
4	Менежментийн захидал	11
4.1	Орлого бүрдүүлэлттэй холбоотой	12
4.2	Авлага, өр төлбөр	13
5	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
5.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
5.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
5.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
5.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн/ тайлан	24
5.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	25
5.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	28
5.7	Аудит хийсэн орон нутгийн орлогын тайлан	29

2 Аудитын гэрчилгээ



2017.03.29 № 98

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Өлзийт сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Архангай аймгийн Аудитын газраас аудит хийв.

Өлзийт сумын төсвийн Ерөнхийлөн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Өлзийт сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь богино хугацаат өр төлбөр **11,935,792.25** төгрөгөөр тайлагнагдаж өмнөх оны мөн үеэс **8,335,144.25** төгрөгөөр буюу 3.3 дахин нэмэгдсэн нь Төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалтыг зөрчсөн

- Сумын орон нутгийн төсвийн орлогыг тайлант жилд **45,245,500** төгрөгөөр төлөвлөж **32,885,613** төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж төсвийн орлого 72.7 хувьтай буюу бүх нэр төрлөөр **12,359,887** төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2 *"Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ"*, 41.2.1 *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"*, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Өмнөх жилийн аудитаар орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл бүрээр төлөвлөгөөний дагуу төвлөрүүлэх зөвлөмжийн биелэлтийг хангаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн *"үнэн зөв байдал"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Өлзийт сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Өлзийт сумын Төсвийн Ерөнхийлөн захирагч Дашдондог овогтой Энхжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Өлзийт сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өлзийт сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.05 - наас 2017.03.23 – ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.23 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аймгийн Аудитын газрын шинжээч Ж.Мөнгөншагай хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017.03.03 - нд төрийн аудитын байгууллагад 1/48 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон улсын стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өлзийт сумын Засаг дарга “Төрийн байгууллага болон төрийн албан хаагчдыг манлайлах ур чадвартай иргэдэд шуурхай үйлчилдэг, цомхон, чадварлаг төрийн алба бүрдүүлж хөгжлийн үзүүлэлтээрээ аймгийн зүүн бүсийн сумдын төв болох” эрхэм зорилгын дор Архангай аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасангийн эрхлэх асуудлын хүрээнд гүйцэтгэж байна.

Өлзийт сумын Засаг даргын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд : Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, САГ/2017/42/СТА-ТШЗ Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ашиглаж байна. Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өлзийт сумын Засаг дарга санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Plastic” програм хангамж ашиглажээ.

3.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Өлзийт сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 40 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 3 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 9 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл дунд буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 3 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

3.6 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Өлзийт сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал **2141.3** сая төгрөг бөгөөд түүний 1 хувь **21.4** сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүн, илэрсэн зөрчил, залруулагдсан алдааг STAUS программд ТАБ-СТА-В-3.1, ТАБ-СТА-В-4.1, ТАБ-СТА-В-4.2, ТАБ-СТА-В-4.3, ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудаар нэгтгэн баримтжуулан хавсаргасан болно.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	24.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	24.8	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

3.8 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1. Өлзийт сумын ИТХ-н төлөөлөгчдийн 2016.12.16-ны өдрийн 06 тоот тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг **45.2** сая төгрөгөөр баталсан боловч 72.5 % буюу **32.8** сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тайлангийн хугацаанд Төсвийн орлого бүх нэр төрлөөрөө буюу нийт дүнгээрээ **12.4** сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2 “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх талаар зөвлөмж хүргүүлсэн бөгөөд энэ нь тайлангийн 4 дүгээр бүлгийн Менежементийн захидалд дурьдагдах болно.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь богино хугацаат өр төлбөр **11.9** төгрөгөөр тайлагнагдаж өмнөх оны мөн үеэс **8.3** төгрөгөөр буюу 3.3 дахин нэмэгдсэн байгаа нь 2015 оны нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн авлага, өр төлбөрийг барагдуулан ажиллах зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгааг харуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Өр төлбөрийг барагдуулан ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн бөгөөд энэ нь тайлангийн 4 дүгээр бүлгийн Менежементийн захидалд дурьдагдах болно.

3.8.1 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дээрх алдаа зөрчлүүд нь Өлзийт сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтийг хязгаарлахад хүргэж байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 28.2 дахь заалтын дагуу буруутай албан хаагчидад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлээ.

3.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төсвийн тухай хуулийн 41.2.1 дахь заалтын дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтын хэрэгжилтийг тулган шалгана.

3.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өлзийт сумын Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой сумын ИТХ-н 2016.12.16-ны өдрийн 06 тоот тогтоолоор хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд **1713.7** сая төгрөгийн, хөрөнгийн зардалд **84.8** сая төгрөгийн нийт **1798.5** сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1798.5	1536.5	85.4%	262.0
1.1	Урсгал зардал	1713.7	1520.6	88.7%	193.2
1.2	Хөрөнгийн зардал	84.8	15.9	18.8%	68.8

Тайлант онд төсвийн гүйцэтгэл 85.4 хувьтай буюу 1536.5 сая төгрөгийн зарцуулалт гарсан байна.

Сумын ИТХ-р баталсан төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү **262.0** сая төгрөг байгаагийн 26.3 % буюу **68.8** сая төгрөг нь ОНХСангийн үлдэгдэл, 66.6 % буюу **174.5** сая төгрөг нь СХСангийн дутуу санхүүжилт, 2.1 % буюу **5.4** сая төгрөг нь төсвийн шууд захирагчдын төвлөрүүлэх шилжүүлэг, 0.3 % буюу **0.9** сая төгрөг нь урьд оны үлдэгдэл, 4.7 % буюу **12.4** сая төгрөг нь орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой дутуу санхүүжилт байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016.11.14-ны өдрийн 05 тоот тогтоолоор сум хөгжүүлэх сангийн орлогыг **178.4** сая төгрөгөөр, гүйцэтгэлийг **178.4** сая төгрөгөөр баталсан боловч орлогын гүйцэтгэл хангалтгүйгээс төлөвлөгөөний дагуу иргэд, аж ахуй нэгжид сангаас олгох зээл гарах боломжгүй байсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө **45.2** сая төгрөгөөр батлагдаж 71.9 % буюу **32.5** сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн орлогын төлөвлөгөө бүх нэр төрлөөр **12.4** сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар **22.9** сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

3.11 Шилэн дансны мэдээлэл

Өлзийт сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох мэдээ мэдээллийг цаг тухай бүр шилэн дансны сайтад байршуулаагүй байх магадлалтай байна.

3.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Аймгийн Аудитын газраас өмнөх онд орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл бүр дээр жигд ханган биелүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүйгээс энэ асуудал нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дахин давтагдан гарсан байна.

3.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өлзийт сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Тайлангийн 3.8-д дурьдсан алдаа зөрчлийг эс тооцвол Булган сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “**Хязгаарлалттай**” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 3.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс их байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлтэй байна. / Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв. /

Аудитлагдсан санхүүгийн тайлан /... хуудас/-ыг хавсаргав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2017 оны 3 дугаар сар

4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өлзийт сумын Засаг дарга-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурьдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

4.1 Орлого бүрдүүлэлттэй холбоотой	Тэргүүлэх ач холбогдол 1
---	---------------------------------

Илрүүлэлт

Өлзийт сумын ИТХ-н төлөөлөгчдийн 2016.12.16-ны өдрийн 06 тоот тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогыг **45.2** сая төгрөгөөр баталсан боловч 72.5 % буюу **32.8** сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тайлангийн хугацаанд Төсвийн орлого бүх нэр төрлөөрөө буюу нийт дүнгээрээ **12.4** сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитаас орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр жигд ханган биелүүлэх талаар өмнөх аудитаас зөвлөмж хүргүүлж байсан.

Зөвлөмж

- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл бүр дээр нь хангалттай биелүүлэн ажиллах
- Төсвийн тухай хуулийн 41.2 “**Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ**”, 41.2.1 “**хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх**” гэсэн заалтыг дагаж мөрдөх
- Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллах

Эрсдэл

- Тайлант онд дэвшүүлсэн зорилго, зорилт хангагдахгүй болох

Төсвийн захирагчийн хариу

4.2 Авлага, өр төлбөр

Тэргүүлэх ач
холбогдол 2

Илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь богино хугацаат өр төлбөр **11.9** төгрөгөөр тайлагнагдаж өмнөх оны мөн үеэс **8.3** төгрөгөөр буюу 3.3 дахин нэмэгдсэн байгаа нь 2015 оны нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн авлага, өр төлбөрийг барагдуулан ажиллах зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгааг харуулж байна.

Зөвлөмж

- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өр төлбөрийг бүрэн барагдуулахад онцгой анхаарах.
- Цаашид эдийн үндсэн үзүүлэлттэй уялдуулан, **богино хугацаат өр төлбөр үүсгэхгүй байж** Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасныг мөрдлөгө болгон ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Эрсдэл

- Тайлант оны үр дүнд нөлөөлөх

Хариуцах ажилтан

Архангай аймгийн Аудитын газрын
шинжээч...../Ж.Мөнгөншагай/

Өлзийт сумын Төсвийн ерөнхийлөн
захирагч..... /Д.Энхжаргал/

Санхүүгийн албаны дарга
...../Э.Одбаяр/

5 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	461,541,433.89	498,388,231.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,887,986.19	120,934,020.19
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	40,887,986.19	120,934,020.19
31210	Төгрөг	40,887,986.19	52,101,194.19
31211	Төрийн сангийн харилцах	940,222.19	279,100.19
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	51,822,094.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	39,947,764.00	0.00
31220	Гадаад валют	0.00	68,832,826.00
31223	Арилжааны банк дахь харилцах	0.00	68,832,826.00
33	АВЛАГА	298,441,316.43	275,719,183.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	121,128.43	0.00
33500	Бусад авлага	298,320,188.00	275,719,183.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	298,320,188.00	275,719,183.00
35	БАРАА МАТЕРИАЛ	121,745,981.27	101,265,878.45
35100	Түүхий эд материал	2,273,977.91	425,749.00
35110	Тусгай зориулалттай материал	410,000.00	0.00
35130	Эм боох материал	1,863,977.91	425,749.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	188,400.00	0.00
35400	Хангамжийн материал	119,283,603.36	100,840,129.45
35410	Бичиг хэргийн материал	1,866,820.00	811,145.00
35420	Аж ахуйн материал	106,856,999.36	89,104,098.85
35430	Сэлбэг хэрэгсэл	1,025,000.00	990,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,183,300.00	7,577,760.00
35450	Барилгын засварын материал	5,725,100.00	935,000.00
35460	Хүнсний материал	2,290,204.00	1,271,945.60
35470	Бусад хангамжийн материал	336,180.00	150,180.00
36	НӨӨЦИЙН БАРАА	466,150.00	469,150.00
36600	Бусад нөөц	466,150.00	469,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,413,311,358.15	5,288,782,290.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,413,311,358.15	5,288,782,290.82
39200	Биет хөрөнгө	5,413,311,358.15	5,288,782,290.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,896,565,593.00	8,999,044,697.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,966,300,452.25	-4,125,647,384.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	221,027,776.00	221,027,776.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-103,638,602.71	-142,866,290.07
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	194,301,820.25	190,708,299.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,338,061.83	-121,618,782.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	308,218,514.39	345,476,181.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-165,981,505.90	-197,227,399.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	123,962,996.00	123,962,996.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-29,698,895.22	-42,893,879.98
39217	Ном	37,192,176.42	38,816,078.42
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,874,852,792.04	5,787,170,522.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,600,648.00	11,935,792.25
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,600,648.00	11,935,792.25

41300	Өглөг	3,600,648.00	11,935,792.25
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	7,209,465.00
41360	Бусад өглөг	3,600,648.00	4,726,327.25
41361	Байгууллагад төлөх өглөг	1,700,648.00	810,530.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,900,000.00	3,915,797.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,871,252,144.04	5,775,234,730.21
51	Засгийн газрын хувь оролцоо	5,871,252,144.04	5,775,234,730.21
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,896,581,128.35	1,896,581,128.35
51200	Хуримтлагдсан үр дүн	-875,966,316.33	-971,983,730.16
51210	Өмнөх үеийн үр дүн	53,812,586.41	-884,009,509.33
51220	Тайлант үеийн үр дүн	-929,778,902.74	-87,974,220.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,850,637,332.02	4,850,637,332.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,874,852,792.04	5,787,170,522.46

5.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,239,246,293.64	2,053,367,042.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,411,886.00	32,254,882.00
110	Орлогын албан татвар	19,669,666.00	22,209,612.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	19,339,666.00	22,209,612.00
110002	Үйл ажиллагааны орлого	19,286,466.00	22,209,612.00
110004	Хөрөнгө борлуулсны орлого	53,200.00	0.00
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	330,000.00	0.00
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	330,000.00	0.00
113	Хөрөнгийн албан татвар	727,000.00	3,160,000.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.00	160,000.00
113002	Бууны албан татвар	727,000.00	3,000,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	8,015,220.00	6,885,270.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,906,900.00	3,188,130.00
